

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

**/2016 оны хагас жил/**

Д/д	Уртболондундхугацааных өтөлбөр, бодлогынбаримтбичиг	Зорилт, аргахэмжээ	Шалгуур үзүүлэлт	2016 онд хүрэх түвшин, үр дүн	2016 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/	Хэрэгжилт	Яамны үнэл гээ	СЯ-ын үнэлгээ	Тайлбар
1	2	3	4	5	6	7			
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>									
<b>Зорилт 2.Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.</b>									
2.1	ҮХЦБ-ын 5.1.5, 2.2.1 дэхзорилт,  ЗГҮАХХАХТ-ний 28 дахьзаалт	Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум ам.доллар	1.8	-	Засгийн газрын 2015 оны 511 тогтоолыг батлуулан Ашигт хайгуулын тусгай зөвшөөрөл олгож эхэлсэн. Энэ ажлын үр дүнд Геологи хайгуулын салбарт гадаадын хөрөнгө оруулалттай болон хамтарсан 386 тусгай зөвшөөрөл болж өсөөд байна. 2016 оны эхний хагас жилийн байдлаар 2015 онд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж 98,890,953,086 төгрөг хөрөнгө оруулалт хийсэн байна. /2016 хайгуулын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтын нэгтгэл 2017 оны эхний хагаст гарна./	100		
2.4	ЗГҮАХХАХТ-ний 51.1 дэхзаалт, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид “ТЭБСББ” гэх/-ын 3.3.2 дахь заалт	Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	Ажлын явц, хувиар	20-иос дээш	-	Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулахтай холбогдуулан Улсын Их Хурлын шийдвэрүүд, тус төслийн хэрэгжилтийн явцад гарч байгаа зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор уг ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах талаар хөрөнгө оруулагч талтай өмнө нь хийсэн яриа хэлэлцээг үргэлжлүүлэх үүрэг бүхий Засгийн газрын Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Оюутолгойн уулын баяжуулах үйлдвэрийг Улсын комиссоор хүлээж авсан. Үйлдвэрийн анхны баяжмалыг 2013 оны эхний хагас жилээс экспортод гаргаж, “Эрдэнэс Оюутолгой” ХК болон “Оюутолгой” ХХК-ийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна. “Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн	100		

						<p>төлөвлөгөө"-г Хөрөнгө оруулагч талтай 2015 оны 5-р сарын 18-ны өдөр байгуулж төслийн хүрээнд тулгамдаад байсан асуудлыг шийдвэрлэж далд уурхайн бүтээн байгуулалтыг ажлыг эрчимжүүлэхээр талууд тохиролцсон. Оюутолгойн бүлэг ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 6-р сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж холбогдох засварыг хийлгэж хүлээж авахаар шийдвэрлэсэн.</p> <p>Далд уурхайн ажлын туслан гүйцэтгэгч болох "Ред Пат" ХХК-ийн тэсэлгээний тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгох асуудлыг шийдвэрлүүлж, төслийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.</p>			
2.5	ЗГҮАХХАХТ-ний 52 дахь заалт	Таван толгойн төслийг үргэлжлүүлэх	Ажлын явц, хувиар	20.0 –иос дээш	-	<p>Тавантолгойн нүүрсийг хуурай аргаар баяжуулах технологийн туршилтыг хийлгэсэн. Цанхийн хэсгийн 0 давхаргыг дээрх аргаар баяжуулах боломжийг судалсан. Тавантолгойн ордод хөрөнгө оруулж хамтран ажиллах олон улсын консорциумыг сонгон шалгаруулах, хөрөнгө оруулалтын болон хамтран ажиллах гэрээний төсөл боловсруулахад бодлогын дэмжлэг үзүүлж ажилласан. Тавантолгойн ордод хөрөнгө оруулж, хамтран ажиллах олон улсын консорциум /Хятадын Шиньхуа Энержи компани, Монголын "Энержи Ресурс" ХХК, "ММС" ХХК, Японы Сумитомо/-тай яриа хэлэлцээ хийж, гэрээ байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлж, холбогдох санал дүгнэлт гаргаж, ажилласан. Эрдэнэс Тавантолгойн уурхай 20 дахь сая тн нүүрсээ олборлоод байна.</p>	100		
<b>ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО</b>									
<b>Зорилт 5. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.</b>									
5.1	ЗГҮАХХАХТ-ний 99.1 дэх заалт	Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг	ТЭЗҮ, зураг төсөл боловсруул ах ажлын явц, хувиар	100.0	14.0 Хувийн хэвшил, Гадаад	<p>Дархан газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийг Япон улсын JVIC банкны зээлийн санхүүжилтээр шийдвэрлэхээр ажиллаж, хэд хэдэн удаа Засгийн газрын хуралдаанаар асуудал хэлэлцүүлсэн бөгөөд хамгийн сүүлд 2013 оны 1 дүгээр сарын 12-ны</p>			

		боловсруулах			<p>эх үүсвэр</p> <p>өдөр 30 тоот тогтоол гаргуулсан. Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэрийн Техникийн зураг төслийн ажил (ТЗТА)-ыг гүйцэтгэх болон уг ажлын төлбөрийн тухай гэрээг Монголын талаас Уул уурхайн яам, “Дархан-Газрын тос боловсруулах үйлдвэр” компани, Японы талаас Тоёо инженеринг корпорацийн хооронд 2013 оны 5 дугаар сард байгуулж гэрээний дагуу Японы Тоёо инженеринг корпораци Техникийн зураг төслийг 2014 оны 2 дугаар сард “Дархан-газрын тос боловсруулах үйлдвэр” ХХК-д ирүүлсэн.</p> <p>Техникийн зураг төслөөр тус Корпораци уг үйлдвэрийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхэд гарах зардал нь төсөвлөж байснаас 2 дахин нэмэгдсэн үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэх боломжгүй гэдгээ төслийн ерөнхий зохицуулагч Марубени корпорацид мэдэгдсэн. Ингээд Марубени корпораци үйлдвэр барих асуудлыг Японы Чиёда компанид тавьж үйлдвэр барих асуудлаар тохиролцоонд хүрсэн байна. Чиёда компани нь Тоёо инженеринг корпорацийн хийсэн ТЗТА-ыг дахин боловсруулах, өөрсдийн тооцоо судалгаанд үндэслэсэн шинэчлэх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнд шаардагдах 2,3 сая ам.долларыг Монголын Засгийн газраас гаргуулах хүсэлтийг тавьсан. Мөн үйлдвэр байгуулах төслийг ҮАБЗ-өөр хэлэлцүүлж 2014 оны 3-р сарын 17-нд ҮАБЗ-өөс <i>“Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах”</i> Зөвлөмжийг гаргасан. Д-ГТБҮ-ийн төслийг Монгол улсын төр засгаас гаргасан бодлогын баримт бичгүүдтэй (ҮАБГ-ын Зөвлөмж, "Монгол улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр", "Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого", "Газрын тосны тухай хууль"-ийн шинэчилсэн найруулга) уялдуулан, хэтийн төлөвлөгөөнд тусгагдсан аж үйлдвэрийн шинэ төвүүд болон газрын тосны ирээдүй бүхий ордуудтай аль болох ойр байршуулах боломжийг судалж</p>	70		
--	--	--------------	--	--	--	----	--	--

					<p>байж шийдвэрлэхээр тогтсон. ЗГ-ын 2014 оны 402-р тогтоолын дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулах асуудал чиг үүргийн дагуу Аж үйлдвэрийн яаманд шилжээд байна.</p> <p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Газрын тос боловсруулах үйлдвэрийн чиглэлээр 2014 оны 3-р сарын 17-ны өдөр "Стратегийн чухал ач холбогдолтой газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдийг түшиглэн байгуулах" тухай Зөвлөмж гаргасан. Өнөөгийн байдлаар газрын тос боловсруулах, нүүрс хийжүүлэх, шингэрүүлэх болон биодизелийн үйлдвэр барих төсөл боловсруулж тусгай зөвшөөрөл авсан нийт 15 аж ахуйн нэгж байна. Жилд 2 сая тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Говийн бүсэд, 300 мянган тонн хүртэл газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэрийг Зүүн бүсэд байгуулах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардлагатай зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хянаж, санхүүжүүлэх арга хэмжээ авах тухай Засгийн газрын 2015.03.23-ны өдрийн 113 дугаар тогтоол гарсан.</p> <p>Аж үйлдвэрийн яамтай хамтран газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах ажлын хүрээнд Аж үйлдвэрийн Сайдын тушаалаар байгуулагдсан Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд баригдах жилд 2.3 сая тонн хүртэл хүчин чадалтай газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөлд хөрөнгө оруулж, төслийг хэрэгжүүлэх үндэсний компанийн оролцоотой консерциумыг сонгох үүрэг бүхий уралдаант шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнд болон газрын тос боловсруулах хоолой барих төслийн концесс олгох, хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэгт тус тус гишүүнээр орж ажиллаж байна.</p>				
5.2	ЗГҮАХХАХТ-ний 49.3 дахь заалт	Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг	Үйл ажиллагааны хэрэгжилт,	100.0	-	Зэс хайлуулах үйлдвэрийн асуудлыг Аж үйлдвэрийн яам хариуцаж байна. Тус яамны боловсруулсан "Зэс хайлуулах үйлдвэрийн гүйцэтгэчийг сонгон шалгаруулах, үйлдвэрийн хувьцааны 10%-ийг ЗГ үнэ	90		

		шийдвэрлэх	хувиар			төлбөргүй эзэмших тухай” ЗГ-ын тогтоолын төсөлд санал өгч хамтран ажилласан.			
5.3	ЗГҮАХХАХТ-ний 103 дахь заалт	Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	<p><b>Нүүрс хийжүүлэх чиглэлээр:</b> Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 10 дугаар сард БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Уул уурхайн яам тус улсын Синопек групптэй хүрэн нүүрснээс шатдаг хийн түлш үйлдвэрлэх үйлдвэр байгуулахаар тохирсны дагуу МУ-ын Засгийн газрын 2014 оны 74 дүгээр тогтоолоор Уул уурхайн яамны дэргэд хүрэн нүүрсийг хийжүүлэх технологи нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлэх нэгж байгуулахаар шийдвэрлэж Уул уурхайн сайдын 57 дугаар тушаалаар төслийн нэгж байгуулагдсан. Засгийн газрын 2014 оны 104 тоот тогтоолыг боловсруулан батлуулж төслийн нэгжийн санхүүжилтийг шийдвэрлүүлэв. Төслийн нэгж нь Хятадын талын судалгааны багтай хамтран урьдчилсан ТЭЗҮ боловсруулж дууссан. Мөн Уул уурхайн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороотой “Нүүрсний гүн боловсруулалтыг эрчимжүүлэх салбарын хамтын ажиллагааны тухай” харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийг цааш үргэлжлүүлж, жилд 2 тэрбум шоо метр хүчин чадалтай үйлдвэрийг Багануурын уурхайн хүрэн нүүрсэн дээр төлөвлөж, төслийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг багасгах боломжуудыг харьцуулсан судалгааг явуулж байна. Санамж бичгийн дагуу жилд 16 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр нь 5-8 жилд баригдах тул Уул уурхайн яам, төслийн нэгжээс УБ хотын гэр хорооллыг богино хугацаанд нүүрсний хийгээр хангаж, агаарын бохирдлыг дорвитой бууруулах “УБ хотын гэр хорооллыг хангах Нүүрсний хийн үйлдвэр” ба “УБ хотын Хийн хангамж” төслийг санаачилж, урьдчилсан ТЭЗҮ боловсруулан БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх хүсэлтийг Сангийн яаманд гаргасан. Ажлын үр дүнд, 2013 оны 03 сарын 30-нд баталсан БНХАУ-ын Засгийн Газраас Монгол Улсын</p>	70		

					<p>Засгийн Газарт олгох 500 сая ам. долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн хавсралтанд энэхүү төслийг оруулж, Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 135-р тогтоолоор батлуулсан.</p> <p><b>Нүүрс шингэрүүлэх чиглэлээр:</b> Үйлдвэр хөдөө аж ахуйн яаман /хуучин нэрээр/ дээр нүүрс шингэрүүлэх CTL төслийн нэгж 2013 онд байгуулагдан ажиллаж байгаад Төрийн өмч давамгайлсан компани болсон бөгөөд компанийн удирдах зөвлөлд Түлшний бодлого зохицуулалтын газрын дарга ажиллаж байна. Нүүрс шингэрүүлж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг “МАК Си Ти Эл” ХХК, “Багануур энержи корпорейшн” ХХК-д олгоод байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд тус бүртээ жилдээ 456 мянган тонн дизель түлш, 450 мянган тонн бензин, 100 мянган тонн шингэрүүлсэн хий үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэрүүдийг байгуулж, 2017-2018 ашиглалтанд оруулах урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлээ боловсруулж, Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Токио хотод болсон “Азийн ирээдүй” чуулганы үеэр Япон Улсын нүүрс хийжүүлэх технологийг Монгол Улсад нэвтрүүлэх талаар онцгойлон дурдсан болно. Үүний дагуу Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамнаас 2016 оны 03 дугаар сард Монгол Улсын Уул уурхайн яам, Япон Улсын Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яамтай хамтран “Цэвэр нүүрсний технологи” семинарыг зохион байгуулсны зэрэгцээ энэ оны 06 дугаар сард “Цэвэр нүүрсний салбарт хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийг тус тус байгууллаа. Цаашид нүүрс-химийн аж үйлдвэрийн үндэс суурийг Монгол улсад тавьж хөгжүүлэх зорилгоор нүүрс химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний судалгаа”-ны ажлыг Япон улстай хамтран хэрэгжүүлэх санал боловсруулж тус улсын Эдийн засаг,</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

						худалдаа, аж үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Мөн Уул уурхайн сайдын 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А/48 дугаартай тушаалаар Монгол Японы Засгийн газар хооронд хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд нүүрсийг байгаль орчинд халгүй технологиор үр дүнтэй ашиглах, боловсруулах, Япон улсын технологийг Монгол Улсад нэвтрүүлэх боломжийг тодорхойлох зорилгоор тус улсын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах Ажлын хэсгийг төр хувийн хэвшлийн хамтарсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллаж байна.			
5.7	ЗГҮАХХҮАТ-ний 103.1 дэх заалт	Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны 10 дугаар сард БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Уул уурхайн яам болон БНХАУ-ын Синопек корпорацийн хооронд “Монгол Улсад нүүрснээс байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох төсөл хэрэгжүүлэх тухай” санамж бичиг байгуулсан. 2014-2015 оны хооронд БНХАУ-ын Синопек корпорацитай хамтран Монгол Улсын зүүн бүсийн нүүрсний ордуудыг түшиглэн нүүрснээс синтетик байгалийн хийн үйлдвэр байгуулах, хий экспортлох төслийн урьдчилсан Техник эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/-ийг боловсруулсан. Төслийн хүрээнд жилд 8 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх 2 үйлдвэрийг Цайдамнуурын болон Эрдэнэцогтын ордуудыг түшиглэн байгуулах бөгөөд үйлдвэр ашиглалтад орсноор Эрдэнэцогт болон Цайдам нуурын нүүрсний ордуудад жилд 80 сая тонн нүүрс олборлох нүүрсний ил уурхай байгуулагдаж, хийн үйлдвэрүүд нь 50 жилийн туршид жилд 16 тэрбум шоо метр байгалийн хий үйлдвэрлэх юм.	100		

5.8	ЗГҮАХХҮАТ-ний 67.10 дахьяалт	Шивээ- Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх	Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар	100.0	-	Монгол-Хятадын талын хамтарсан уулзалтыг 2016 оны 5 дугаар сард УУЯ дээр зохион байгуулсан бөгөөд Хятадын талаас ТЭЗҮ-ээ боловсруулж, харин манай талаас Монгол Улсын стандарт, загварт нийцүүлэх үүрэг бүхий тусгай зөвшөөрөлтэй ААН-ийг хамтран ажиллуулахаар тохиролцсон болно. “Эрчим хүчний экспортын Шивээ-Энержи цогцолбор” төслийн нэгж байгуулагдан ажиллаж байна.	100		
-----	---------------------------------	---	--	-------	---	---	-----	--	--

**Зорилт 7.Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.**

7.5	ЗГҮАХХАХТ-ний 67.10 дахь заалт	Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хангах зорилгоор Багануур, Шивээ- Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх	Хүчин чадлын нэмэгдэх хэмжээ	2 дахин	-	Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн технологийн шинэчлэлд шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас санал авч нэгтгэсэн. Тогтоолын төслийг холбогдох материалын хамт Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу хариуцсан чиг үүргийн Сангийн яаманд уламжлан хүргүүлсэн. Сангийн яамнаас уг тогтоолын төслийг Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Засгийн газрын 219 дүгээр тогтоолоор батлуулсан. - ЭХЯ-ны эрхлэх асуудлын хүрээнд Шивээ-Овоогийн уурхайг түшиглэн шинэ ДЦС байгуулах, уурхайн хүчин чадлыг өргөтгөх, ус хангамжийн судалгааны ажлыг “Шивээ Энержи” ХХК гүйцэтгэж байна. - “Багануур” ХК-ийн нүүрсний нөөцийг өсгөж, шинэчлэн бүртгүүлсэнтэй холбогдуулан орд ашиглах ТЭЗҮ-ийг Дэлхийн банкны санхүүжилтээр Австрали улсын “Range Pincok Minarco” болон “Балчулуу” ХХК-иуд боловсруулж байна.	100		
-----	-----------------------------------	---	---------------------------------------	---------	---	--	-----	--	--

**Зорилт 9.Геологи, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.**

	ҮХЦБ-ын 5.2.1.1	Нутаг дэвсгэрийн				-Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан геологийн зураглалын ерөнхий эрлийн ажлаар нийт			
--	-----------------	---------------------	--	--	--	--	--	--	--



9.1	дэхзорилт, ЗГҮАХХАХТ-ний 38.1 дэхзаалт	геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар	40.0	10.0  Улсын төсөв	<p>нутаг дэвсгэрийн 40%-ийг хамруулах зорилтын хүрээнд 2015 онд шинээр 14 төсөл, 3 бүлэгчилсэн төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр ажлыг эхлүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 36% хамрагдсан. 2015 онд эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан шинээр төсөл хэрэгжүүлэх боломжгүй болсон.</p> <p>Эдгээр ажлын үр дүнг авч үзвэл:</p> <p>-2010-2012 онд хэрэгжиж дууссан Баянмөнх-50, Донгой гол-50, Намалзах-50, Дуулгат уул-50, Дадал-50, Хутаг-Өндөр-50, Баянзүрх-50, Дайргат-50 төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах тухай УУС-ын 2014 оны 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27-р тушаалыг гаргуулан шийдвэрлүүлсэн.</p> <p>-2011-2014 онд хэрэгжүүлж дууссан Манлай-50, Мандалговь-50 төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авах тухай УУС-ын 103, 104-р тушаалыг гаргуулан хүлээн авсан.</p> <p>-2012-2014 онд хэрэгжүүлж дууссан Сэрвэн уул-50, Замлин богд-50, Өнгөтийн нуруу-50, Рашаант уул-50, Хавирга уул-50, Хавтгай уул-50, Бардам уул-50, Ихэрийн хяр-50 төслийн үр дүнгийн тайланг хүлээн авах тухай УУС-ын 2015 оны 13, 38-42, 86, 87-р тушаалыг гаргуулан хүлээн авсан.</p> <p>-2014 оноос шинээр хэрэгжүүлэх 17 төслийн ажлын төлөвлөгөө, төсөвийг УУС-ын 48-р тушаалаар батлуулсан. Төсөл хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. 2013-2015, 2013-2016, 2014-2016, 2014-2018 онд хэрэгжих 28 төслийн 2015 оны ажлын төлөвлөгөө, төсөвийг УУС-ын 2015 оны 33-р тушаалаар батлуулсан. 2011-2014 онд хэрэгжиж дууссан 8 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж, УУС-ын 2015 оны 13, 38-42, 86, 87, 121, 173, 174 дүгээр тушаалаар хүлээн авч шийдвэрлэсэн. Төслүүдийн 2015 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн шийдвэрлэсэн. Төслүүдийн 2015 оны хээрийн судалгааны ажлын материалыг хүлээн авсан. Мөн төслүүдийн 2015 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг хийж</p>	100		
-----	--	--	--	------	----------------------------	---	-----	--	--

					<p>зөвлөмж өгсөн.</p> <p>- Тайлант хугацаанд Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн болон гүйцэтгэж байгаа "1:50000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил"-ын мэдээллийн санг үүсгэн, хэрэгжилтийн үр дүнг нэгтгэх ажил хийгдсэн.</p> <p>- 2016 онд УТХ-өөр шинээр эхлүүлэх 1:50000-ны масштабын ГЗЕЭА-ын төслүүдийн төлөвлөлтийн санал, геологийн даалгаврын төслийг боловсруулсан. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ГСА-ын Тогоо хайрхан-50, Эмээлцэгийн нуруу-50 төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн УТХ-ийн 1-р хуралдаанаар 2016.04.07-ны өдөр хэлэлцүүлсэн.</p> <p>Цогт-50, Улаанбадрах-50, Тахилт-50, Хайрхан уул-50, Онц уул-50 төслүүдийн үр дүнгийн тайланд хяналт хийж, ЭБМЗ-ийн УТХ-ийн 2-р хуралдаанаар буюу 2016.07.01-ны өдөр хэлэлцүүлсэн.</p> <p>Дээрх төслүүдэд тайлангийн шуурхайн хяналт хийсэн 15 хурлын тэмдэглэл, төслийн танилцуулга, ИТА нарын мэдээ, хяналтын хуудас, бусад баримтын хамт бүрдүүлж, хяналтын нэгтгэлийг хийсэн.</p> <p>- 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Улаантолгой-50, Өлийн-Овоот-50, Ар чулуут-50, Суманхад-50, Чандмань Уул-50, Хайлааст Уул-50, Алтай нуруу-50, Шивээт Уул-50 “Бударын чулуу-50”, “Хулгарын элс-50”, “Тойромын хөндий-50” төсөл, “Эргэлийн зоо-50”, “Хөхөлзөгийн говь-50”, Баян-Индэр-50 төслүүдийн хэрэгжилтийн явцад завсрын шуурхай хяналтыг 2016 оны 4-р сарын 16-наас 5-р сарын 6-ны хооронд хийсэн.</p> <p>Дээрх төслүүдэд тайлангийн шуурхайн хяналт хийсэн 14 хурлын тэмдэглэл, төслийн танилцуулга, ИТА нарын мэдээ, хяналтын хуудас, бусад баримтын хамт бүрдүүлж, хяналтын нэгтгэлийг хийсэн.</p> <p>- БНЧех улстай хамтарсан 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн “Монгол Алтай-50”, төслийн эцсийн үр дүнгийн тайланд шуурхай хяналт хийж хүлээн авч эхлээд байна. 2016 онд Улсын төсвийн</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

						хөрөнгөөр гүйцэтгэх "1:50000-ын масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг шинээр 10 талбайд зарлан сонгон шалгаруулалтыг явуулаад байна.			
9.2	ЗГҮАХХАХТ-ний 100.1, 100.2 дахь заалт, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого 3.5.7 дахь заалт	Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх	Барилгын ажлын явц, хувиар	50.0	19.0 ТХХТ	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх үүднээс Засгийн газрын 2015 оны 119 дүгээр тогтоолоор Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг концессоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүний дагуу "Эн Ти Ти групп" ХХК-д барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгүүлэхээр шийдвэрлэж дараах ажлууд хийгдсэн. Үүнд: Засгийн газар болон "Эн Ти Ти групп" ХХК-ийн хооронд "Рашаант дахь улсын нөөцийн агуулах төслийг хэрэгжүүлэх концессын гэрээ", "Нефть ойл" ХХК болон "Нэйшнл трейдинг энд транспорт групп" ХХК-ийн хооронд төлбөрийн гэрээг тус тус байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, ажлын зураг төсөл, техникийн нөхцлүүд, барилга угсралтын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, хийгдсэн ажлын гүйцэтгэл ба санхүүжилтийн танилцуулга, барилга угсралтын ил, далд ажлын актууд, барилга угсралтын ажилд хэрэглэсэн түүхий эд, бараа материалын талаарх хөндлөнгийн шинжилгээний лабораторийн дүгнэлтүүд зэрэг холбогдох бичиг баримтуудыг "Эн Ти Ти групп" ХХК-д бүрэн гүйцэд шилжүүлэн өгсөн. Төслийг концесст шилжүүлэхээс өмнө хийгдсэн бэлтгэл ажлууд болон бодит хийгдсэн ажлуудтай холбогдон гарсан нийт бодит зардлыг тооцож шийдвэрлүүлсэн. Төслийн хүчин чадлыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор зураг төслийн ажлын даалгавар боловсруулж "Эн Ти Ти групп" ХХК-д хүргүүлсэн.	100		
9.3	ТЭБСББ-ын 3.3.3 дахь заалт	Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх	Ашиглалта д оруулах ордын тоо	25.0-аас доошгүй	-	- Стратегийн орд газруудад төрийн эзэмшлийн хувь хэмжээг орд ашиглах гэрээ байгуулах замаар шийдвэрлэх тухай Ашигт малтмалын тухай хуульд 27 <sup>2</sup> заалт нэмэлтээр орсонтой холбогдуулан Гацууртын ордыг ашиглах гэрээг байгуулах ажлын хэсэг, Уул уурхайн сайдын тушаалаар байгуулагдан Сентерра Голд ХХК-тай Орд ашиглах гэрээ	100		

					байгуулах ажлын хэсэгт тус тус орж ажиллан хэлэлцээр хийхэд шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна. - Ашиглахад бэлэн болсон уурхай, уулын үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах Улсын комиссын бүрэлдэхүүнд ажиллаж 13 уурхайг хүлээн аваад байна.				
9.4	ЗГҮАХ-ийн 40.12 Дахь заалт	Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх	Шинээр мөрдүүлэх үндэсний стандартын тоо	9	-	БОНХАЖЯ-аас 2012-2015 онд нийт 39 стандартыг шинээр болон шинэчилэн боловсруулж батлуулсан байна. Үүнд: 2012 онд 5, 2013 онд 5, 2014 онд 13, 2015 онд 16 стандартын төслийг боловсруулан холбогдох стандартчиллын техникийн хорооны хурлаар хэлэлцүүлж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар батлуулсан. Дээрх стандартуудын хэлэцүүлэгт оролцож санал дүгнэлтээ тухай бүр өгч хамтран ажиллалаа. Тухайлбал: - Уул уурхайн нөхөн сэргээлттэй холбогдох Олон улсын стандартчиллын Уурхайн орхигдсон газрын асуудалтай талбай, төлөвлөлтийн нэгж, түлхүүр үгний заалт, төслийн талбайг хамруулан гадаргын орон зайн мэдээлэл бэлтгэх стандарт аргачлал MNS ASTM 7699, Хөрсний чанар – Хөрс бохирдуулагчаас ургамалд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох туршилт ISO11269-2, Нүүрсний шаталтын бүтээгдэхүүн (НШБ)-ийг ил уурхайн нөхөн сэргээлтэд ашиглах стандарт заавар: Ургамалжуулалт болон уурхайн хүчиллэг урсацыг бууруулахад ашиглах. MNS ASTM E 2278, Шохой шатаах болон портланд цемент үйлдвэрлэх зуухнаас гарах тоосыг ашиглах зөвлөмж MNS ASTM D5050, Газрын тос боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, түүний хаягдлын байгууламжид тавигдах шаардлага болон Хаягдал лагийн ангилал – Эвдэрсэн газрын хөрсний нөхөн сэргээлтэд хаягдлын лагийг ашиглах дэвшилтэт туршлага CEN/TR 13983 зэрэг стандартыг үндэсний стандартаар батлууллаа. - Ой модыг нөөцийг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр Ойн арчилгаа, цэвэрлэгээний болон үндсэн ашиглалтын огтлолтод тавигдах ерөнхий шаардлага,	100		

					<p>Модны үр. Үр түүх ойн талбайг тусгаарлах арга,Түймрээс ойг хамгаалах.Түймрийн эсрэг ойн зааг, шороон зурвас. Чанарын шалгуур ба өгөгдөх үнэлгээ болон ойн хортонтой тэмцэх, ойн дагалт баялаг ашиглахтай холбоотой 17 багц стандартын төслийг боловсруулан Монгол улсын үндэсний стандартаар батлуулсан.</p> <p>Усны нөөцийг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор “Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал бохир ус. Ерөнхий шаардлага”, “Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын төслийг боловсруулан Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.</p> <p>- Уул уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ЕвропынХолбооны30 гаруй стандартыг судлаад 2013-2014 онд нэн шаардлагатай 14 стандартын төслийг боловсруулсан. Тухайлбал:</p> <p>1. Ашигт малтмалын боловсруулалтаас гарч буй өтгөрүүлсэн ба хуурайшуулсан хаягдлыг агуулах байгууламж, хийц, ашиглалтын болон хаалтын үйл ажиллагааны хяналт-шинжилгээний ажил, түүнд тавих шаардлага зэргийн 6 багц системчилсэн стандартын төслийг эцэслэн боловсруулж, Стандартчилал хэмжил зүйн газрын Үндэсний зөвлөлийн 2014 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар хэлэлцүүлээ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн зэрэглэл</li> <li>• Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламж. Ерөнхий шаардлага</li> <li>• Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн шороон боомтын хийц, материалын нягтруулга</li> <li>• Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн геонийлэг доторлогоо. Техникийн шаардлага</li> </ul> <p>Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн ашиглалтын</p>			
--	--	--	--	--	---	--	--	--

					<p>үйл ажиллагааны хяналт, шинжилгээ. Техникийн шаардлага зэргийг хэлэлцүүлж. 3 стандартыг батлуулаад байна.</p> <p>Германы хамтын ажиллагааны газрын санхүүжилтээр байгуулагдсан ажлын хэсгийн 2015 оны 4 удаагийн хуралд оролцон уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн дүнгээс эвдрэлд оруулсан талбайн хүрээнд нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээнд үндэслэн мэдээллээр ханган ажиллах, “Уул уурхайн салбарын байгаль орчны эрх зүйн өнөөгийн байдал” сэдвээр мэдээлэл бэлтгэн ажлын хэсгийн хэлэлцүүлэгт хэлэлцүүлээ. Байгаль орчинд учруулсан хохирол тооцох аргачлалын шинэчлэсэн төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан БОАЖНХЯ-нд аргачлалын төсөл хүргүүлсэн. 2016 оны 1 дүгээр сарын 12-ны А/14 тоот Ил уурхай дэд бүтцийн төслөөс Байгаль орчинд учруулсан хохирлыг тооцох түр аргачлал батлагдсан. Тус аргачлалын туршилтын хугацаанд Байгаль орчны хохирол тооцох “амьдрах орчны үнэлгээний аргачлал”-ыг ашиглах гарын авлага БОНХАЖЯ-наас хэвлэгдэн гарсантай холбогдон сургалт, уулзалтанд хамрагдан ажиллалаа.</p> <p>Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөртэй хамтран “Ашигт малтмалыг баяжуулах, ялгах бутлах ба хүдэр, баяжмалыг бөөнцөглөх аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн төслийг боловсруулсан. “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”, Геологи хайгуулын ажлын үед мөрдөх ХАА-ны нэгдсэн дүрмийг шинэчлэн боловсруулж байна. Мөн уул уурхайн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд мөрдөх техникийн зохицуулалтын төслийг тус тус боловсруулсан.</p>	100			
9.5	ЗГҮАХХҮАТ-ний 60.1 дэх заалт	Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрын нөхөн сэргээлтийг санхүүжүүлэх зорилгоор 2013 онд “Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрын нөхөн сэргээлтийг санхүүжүүлэх хууль”-ийн төслийн анхны хувилбарыг боловсруулсан. Хуулийн төслийн концепцийг шинэчилж, “Газрын тос,			

		хийлгүүлэх				<p>ашигт малтмалын нөөц ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь, хэмжээний тухай хууль"-ийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, БОНХЯ-ны 2014 оны 11-р сарын 13-ны өдрийн 1/6470 албан тоотоор ЗГХЭГ-т хүргүүлээд байна.</p> <p>Нөхөн сэргээлтийн мэдээллийн нэгдсэн санг БОНХАЖЯ-тай хамтран байгуулж, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.</p> <p>Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгэх ажлыг эрчимжүүлж, орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд холбогдох арга хэмжээ, зардлын төсвийг тусгуулж байна. БОНХАЖЯ-ны тусгай санд Байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг байршуулж байна.</p>	90		
<b>ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО</b>									
<b>Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.</b>									
12.8	<p>ҮХЦБ-ын 5.3.2 дахьзаалт</p> <p>ЗГҮАХХҮАТ-ний 100 дахьзаалт</p>	<p>Эрчим хүч, авто бензин, дизелийн түлшний үнийг Монгол Улсын хэмжээнд ижил байх эрх орчныг бүрдүүлэх</p>	<p>Үйл ажиллагаан улсын хэрэгжилт, хувиар</p>	100.0	-	<p>Алслагдсан аймаг сум, орон нутаг дах шатахууны жижиглэнгийн үнийг Улаанбаатар хотын үнэтэй ойролцоо төвшинд хүргэх ажлыг үе шаттайгаар тогтмол зохион байгуулсан. 2016 онд шатахууны үнийг төрөл тутамд баруун бүсэд 80-400 төгрөгөөр, зүүн бүсэд 10-230 төгрөгөөр тус тус бууруулсан ба Өмнөговь, Дорноговь, Хөвсгөл, Архангай зэрэг аймгуудад шатахууны үнэ 100-150 төгрөгөөр буурсан бол 2016 оны 1 дүгээр сараас Улаанбаатар хотод шатахууны үнэ төрөл тутамдаа 80-150 төгрөгөөр буурсан болно.</p>	100		
	Нийт үнэлгээ						95,0		

-----oOo-----

УУЛ УУРХАЙН ЯАМНЫ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР